



**БЛАН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/146

Өлгий

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 хэсэг, аймгийн ИТХ-ын 2017 оны V хуралдааны 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж "ИЕЛ" ХХК-ийн гүйцэтгэсэн Сагсай сумын Засаг даргын Тамгын газарт албаны авто машин худалдан авах ажиллагааг ашиглалтад хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга	З.Болат	- ХОХБТХ-ийн дарга
Гишүүд	С.Хонаев Х.Холганат Н.Сабит	- Сагсай сумын Засаг дарга - "ИЕЛ" ХХ-ийн захирал - Сагсай сумын ЗДТГ-ын жолооч
Нарийн бичгийн дарга	Х.Бахытгүл	-ОНӨГ-ын мэргэжилтэн

2.Сагсай сумын Засаг даргын Тамгын газарт худалдан авсан албаны авто машиныг хүлээн авахад захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдсэн авто машиныг тусгагдсан техникийн шаардлагыг хангасан байдал болон холбогдох баримтуудтай газар дээр нь танилцаж, шалгаж авсан тухай акт үйлдэн хөрөнгөд бүртгэн авч холбогдох эд хариуцагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комисс / З.Болат /-т үүрэг болгосугай.

3.Цаашид шинээр хүлээн авсан авто машиныг үндсэн хөрөнгөд бүртгүүлж, ашиглах ажлыг зохих хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Сагсай сумын Засаг даргын Тамгын газрын дарга / А. Шепен /-т үүрэг болгосугай.

